



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

до 13 оны 11 сарын 06 өдөр


Дугаар 411

Улаанбаатар хот

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн
дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан бүтэц, дүрмийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгож ажиллахыг тус Төв /Г.Баясгалан/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуюя/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2006 оны 192 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
193



Эрүүл мэндийн сайдын
2013 оны 11 сарын 06 өдрийн
41 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Улсын хоёрдугаар төв эмнэлэг (цаашид Төв эмнэлэг гэх) нь эмнэл зүйн төрөлжсөн мэргэжлийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий лавлагаа төв мөн.

1.2 Төв эмнэлэг нь хүн амд өөрийн үзүүлж буй тусlamж, үйлчилгээний чиглэлээр төрөлжсөн мэргэжлээр эмнэлгийн лавлагаа тусlamж, үйлчилгээг үзүүлэх, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, аргачлал боловсруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах, хүн амын өвчлөл, өвчний тархалт, нас бааралтыг тандан судлах, судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллага мөн.

1.3 Төв эмнэлэг нь өөрийн үзүүлж буй тусlamж, үйлчилгээний чиглэлээр улсын хэмжээнд эмнэлзүйн төрөлжсөн мэргэжлийн дүгнэлт гаргаж, зөвлөгөө өгөх байгууллага мөн.

1.4 Төв эмнэлэг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, бусад хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам болон өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Эрүүл мэндийн сайдаар батлуулсан байгууллагын бүтэц, дурмийн дагуу үйл ажиллагаа явуулна.

1.5 Төв эмнэлэг нь байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байна.

1.6 Төв эмнэлэг нь Улаанбаатар хотод өөрийн байранд байрлан үйл ажиллагаа явуулна. Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө-49

1.7 Төв эмнэлгийн нэрийг англи хэл дээр "Second State Central Hospital" гэж орчуулна.

1.8 Төв эмнэлэг нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

2.1. Төв эмнэлэг нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Үйлчлүүлэгчийг дээдлэх;
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн, нууцлалыг сахих;
- Тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;
- Тусlamж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах;
- Тусlamж, үйлчилгээг үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
- Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангах;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх;

2.2. Төв эмнэлгийн эрхэм зорилго нь: Эрүүл мэндийн цогц, шуурхай, чанартай үйлчилгээг өндөр мэдлэг, чадвар бүхий эмч, мэргэжилтнүүд дэвшилтэт технологид тулгуурлан үзүүлж, үйлчилгээний амьдралын чанарыг сайжруулахад оршино.

Гурав. Төв эмнэлгийн эрх, үүрэг

3.1. Төв эмнэлэг нь дараах эрхтэй.

3.1.1. Төв эмнэлгийн үзүүлж буй тусlamж, үйлчилгээний чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэл зүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. Төв эмнэлэг нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц, хүний нөөц, материаллаг бааз, төсвийг бүрдүүлж зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах;

3.1.3. Ижил чиг үүрэг бүхий гадаадын төв эмнэлгүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн, тусlamж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох;

3.1.4. Судалгаа, шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах;

3.1.5. Өөрийн болон гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх асуудлаар гэрээ байгуулах, харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах;

3.1.6. Төв эмнэлэг нь тусlamж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх;

3.1.7. Төв эмнэлэг нь хууль, тогтоомж, төрийн төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу тусlamж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

3.1.8. Хууль, тогтоомжоор олгогдсон бусад эрх.

3.2. Төв эмнэлэг нь дараах үүрэгтэй.

3.2.1. Бусад эрүүл мэндийн байгууллагаас холбогдох журмын дагуу шилжүүлсэн өвчтөнд эмнэлзүйн төрөлжсөн мэргэжлийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, эмчилгээний зөвлөмж, дүгнэлт гаргах;

3.2.2. Бусад эрүүл мэндийн байгууллагын үзүүлж буй тусlamж, үйлчилгээ, оношилгоо, лабораторийн шинжилгээнд лавлагагаа тусlamж үзүүлэх чиглэлээрээ чанарын хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3.2.3. Өөрийн үзүүлж буй тусlamж, үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

3.2.4. Төв эмнэлгийн үзүүлж буй тусlamж, үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, аргачлал боловсруулах;

3.2.5. Өөрийн үзүүлж буй тусlamж, үйлчилгээний чиглэлээр төгсөлтийн дараах албан ба албан бус сургалтыг зохион байгуулах, бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн баг ажиллуулан, ажлын байрны болон зайн сургалт явуулах. Сургалтанд шаардлагатай материаллаг болон хүний нөөцийг бүрдүүлэх;

3.2.6. Тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;



3.2.7. Төв эмнэлэг нь улсын хэмжээнд дараах чиглэлээр лавлагаа үйлчилгээ эрхэлнэ. Үүнд:

1. Дурангийн мэс засал
2. Лаборатори
3. Уян дурангийн оношилгоо эмчилгээ
4. Бөөр судлал
5. Эрчимт эмчилгээ, яаралтай тусlamж
6. Өвдөлт намдаах тусlamж, үйлчилгээ
7. Диабетийн тусlamж, үйлчилгээ
8. Сэргээн засах

3.2.8. Өөрийн үзүүлж буй тусlamж, үйлчилгээний чиглэлээр үйлчлэх хүрээний болон зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах, холбогдох байгууллагыг арга зүйн удирдлагаар хангах хамтран ажиллах;

3.2.9. Төв эмнэлгийн үйлчлэх хүрээний хүн амын дундах өвчлөлийн түвшин, тархалт, нас барагтыг судлах тандалтын тогтолцоог бий болгон мэдээний сан бүрдүүлж төрийн захиргааны төв байгууллага, хүн ам, бусад холбогдох этгээдийг мэдээллээр хангах;

3.2.10. Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн, цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;

3.2.11. Өөрийн үзүүлж буй тусlamж, үйлчилгээний чиглэлээр эмнэлзүйн судалгаа шинжилгээг гүйцэтгэж, оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг боловсронгуй болгоход шаардлагатай нотолгоог бий болгох;

3.2.12. Төв эмнэлэг нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, хүний нөөцийн төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах;;

3.2.13. Төв эмнэлэг нь үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн болон өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

3.2.14. Төв эмнэлэг нь тусlamж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, ирсэн санал, гомдолд дүн шинжилгээ хийж залруулах, арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган ажиллах;

3.2.15. Төв эмнэлэг нь өөрийн үзүүлж буй тусlamж, үйлчилгээний чиглэлээр болон байгууллагын үйл ажиллагаанд олон улсын түвшний итгэмжлэл авсан байх;

3.2.16. Төв эмнэлэг нь санхүү төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан, санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит болон нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж, үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн хувьд үр ашигтайг нь сонгон санхүүжүүлдэг байх;

3.2.17. Төв эмнэлэг нь өөрийн үйл ажиллагаандаа тусlamж, үйлчилгээний онцлогийг тусгасан эрсдэлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжүүлэх;

3.2.18. Төв эмнэлэг нь ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;

3.2.19. Төв эмнэлэг нь ажиллагсдын мэдлэг, үр чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, сахилга, хариуцлагын хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

3.2.20. Хууль, тогтоомжоор олгогдсон бусад үүрэг;

Дөрөв. Төв эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт

- 4.1. Төв эмнэлгийн удирдлагын тогтолцоо нь Эмнэлгийн дарга, түүний дэргэдэх Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөс бүрдэнэ.
- 4.2. Төв эмнэлгийн даргыг Эрүүл мэндийн сайд томилж, чөлөөлнэ.
- 4.3. Төв эмнэлгийн дарга нь Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Стратеги төлөвлөлт эрхэлсэн орлогч дарга болон захиргааны нэгжийн удирдлагуудыг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.
- 4.4. Төв эмнэлэг нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт гаргах үүрэг бүхий албан бус орон тооны Эрдмийн зөвлөл байгуулан ажиллана. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Эмнэлгийн дарга батална.
- 4.5. Төв эмнэлгийн дарга нь тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.
- 4.6. Төв эмнэлэг нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Эмийн эмчилгээ зохицуулах хороо, Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл, Халдварт хяналтын алба, Санал, гомдлын хороо зэрэг албан бус орон тооны хороог байгуулан ажиллана.

4.7. Эмнэлгийн даргын эрх, үүрэг

- 4.7.1. Төв эмнэлгийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг нь хариуцах;
- 4.7.2. Төв эмнэлгийн бүтэц, алба, тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, ойрын болон хэтийн хөгжлийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэнд нь хяналт тавих;
- 4.7.3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төвийн орон тоо, ажиллагсдын цалин, хөлсийг тогтоох;
- 4.7.4. Орлогч дарга, тасгийн эрхлэгч, албадын дарга нарыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;
- 4.7.5. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийн тайланг байгууллагын хамт олны хурлаар хэлэлцүүлэн, мэдээлэх;
- 4.7.6. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр төв эмнэлгийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах;
- 4.7.7. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид ажиллах;
- 4.7.8. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах;

Тав. Төвийн санхүүжилт

Төвийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 5.1. Улсын төсөв;
- 5.2. Эрүүл мэндийн даатгал;
- 5.3. Үндсэн төлбөрт (төлбөрт тусламж, үйлчилгээний орлого, үйлчлүүлэгчийн захиалгаар хийх урьдчилан сэргийлэх үзлэг) ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (хууль, тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон ашиг, орлого гэх мэт);
- 5.4. Төсвийн тухай хуулинд заасны дагуу Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүнээс авсан хандив, тусламж;
- 5.5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 5.6. Хууль, тогтоомжид заасан бусад эх үүсвэр;

Зургаа. Гадаад, дотоод хамтын ажиллагаа

- 6.1. Төв эмнэлгийг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд Эмнэлгийн дарга төлөөлнө;

6.2. Төв эмнэлгийн даргын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтанд суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ;

6.3. Төв эмнэлгийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг Эмнэлгийн дарга шийдвэрлэнэ;

6.4. Төв эмнэлэг нь Төрийн захирагааны төв байгууллагын удирдлагууд, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль, тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг, зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана;

6.5. Төв эмнэлэг нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана;

6.6. Олон улсын болон гадаадын эрүүл мэндийн байгууллагаас мэргэжилтэн, зочид, төлөөлөгч урин хамтран ажиллана;

Долоо. Төв эмнэлгийн орлогч дарга нарын чиг үүрэг

7.1. Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга нь эмнэлзүйн төрөлжсөн мэргэжлийн эмчилгээний тасгууд, поликлиник, нэгдсэн лабораторийн төв, дүрс оношилгооны төв, сэргээн засах эмчилгээний, эм зүйн, ариутгал халдвартгүйтгэлийн, эмчилгээний хоолзүйн тасаг, сувилахуйн албаны хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, нэгдсэн зохион байгуулалтаар удирдаж ажиллана. Төв эмнэлгийн чиг үүргийн хүрээнд үндэсний хэмжээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрийн чиглэлээр өвчлөлийн түвшин, тархалтыг тогтоох тандалт судалгаа явуулах, эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах,

7.2. Стратеги, төлөвлөлт эрхэлсэн орлогч дарга нь эмнэлгийн стратеги төлөвлөлт, эдийн засаг, эрүүл мэндийн даатгал, статистик мэдээлэл, мэдээллийн технологи, цахим бүртгэл, инженер техник, хангамж, үйлчилгээний алба, тасгийн үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар удирдан ажиллах, хөдөлмөрийн аюул

Найм. Төв эмнэлгийн албадын чиг үүрэг

8.1. Чанарын алба

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавих, үнэлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийг мөрдүүлэн, тусламж, үйлчилгээний чанарын мэдээллийн сан байгуулах, үйлчлүүлэгч болон ажилтны дунд сэтгэл ханамжийн судалгаа явуулж үр дүнг тооцон ажиллах, хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх аудит, мэргэжлийн хяналтын шалгалт, магадлан итгэмжлэл, хөндлөнгийн хяналт-шинжилгээний бэлтгэл, үйл ажиллагааг зохион байгуулах, үнэлгээ, дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах,

Хяналт-шинжилгээ, дотоод аудит- төв эмнэлгийн удирдлагын тогтолцооны дэргэд орон тооны бус байдлаар зохион байгууллагдан ажиллах ба байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх, эмнэлзүйн эрсдэлийн бэлэн байдлыг үнэлэх, шаардлагатай үед байгууллагын тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ хийх, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийн талаар үнэлгээ хийх, хяналт шинжилгээний дунд үндэслэн байгууллагын үйл ажиллагаа сайжруулах зөвлөмж гаргах;

8.2. Санхүү, бүртгэлийн алба

Байгууллагын няглан бодох, бүртгэлийг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол Улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай болон Няглан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад нийцсэн харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргахад ач холбогдолтой, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах байдлаар зохион байгуулах,

Санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлاغнах, тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулах, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

8.3. Хүний нөөцийн алба

Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөр, хууль, журам, тушаал, бусад шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах, байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тооцож, төлөвлөх, төлөвлөгөө гарган хангарт, хуваарилалт, байршуулалт хийх, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, ажил үүргийн хуваарилалтад үнэлгээ хийх, байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах, чадавхижуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, багц цагийн баталгаажуулалт хийх, ажилтнуудын хувийн хэрэг, мэдээний санг хөтлөх, тогтмол баяжилт хийх, ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулах, үнэлж дүгнэх, хөдөлмөрийн бүтэээмжийг дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх,

Байгууллагын хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, албан хаагчидтай холбоотой шийдвэр гаргахад удирдлагад дэмжлэг үзүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэх;

8.4. Сургалт, судалгаа, гадаад харилцааны алба

Тухайн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил эрхлэх, судалгааны дүн, зөвлөмж боловсруулах, судалгааны чиглэлээр мэдээний сан үүсгэх, байгууллагын хөгжил, эмчилгээ оношилгооны дэвшилтээ арга технологийн чиглэлээр гадаад харилцааг өргөжүүлэн олон улсын байгууллагатай хамтран ажиллах төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллах,

Олон улсад нэвтэрч буй анагаах ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах, харилцан туршилага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарт оролцох ажлыг зохион байгуулах, өөрийн оронд зохион байгуулах, түүнд холбогдох хүмүүсийг оролцуулах, төгсөлтийн дараахь сургалтыг зохион байгуулах;

8.5. Сувилахуйн алба

Байгууллагын хэмжээнд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, шалган зааварлах, гүйцэтгэлд хяналт тавих, сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварт хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэнд хяналт тавих, чанарыг тасралтгүй дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулан арга хэмжээ авч ажиллах,

8.6. Төлөвлөлт, маркетинг, эдийн засгийн алба

Байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлсон урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг салбарын хэмжээнд дэвшиүүлсэн бодлого шийдвэртэй нийцүүлэн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох,

Байгууллагын хэмжээнд ирэх жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн болон үйл ажиллагааны болон үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авах, байгууллагын цахим хуудсыг ажиллуулах, дээрх асуудлуудаар байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах;


8.8. Инженер техник, хангамж, үйлчилгээ, алба

Байгууллагын барилга, байшин, эд хогшил, түргэн тусламжийн автомашин, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээлэл холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээний холбогдолтой мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, тоног төхөөрөмж ашиглаж ажилладаг тасаг, хэсгүүдийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, гадаад болон дотоод орчны тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээг хийх, эмнэлгийн зөвлөн эдлэлийн, ариутгал, халдвартгүйтгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэх, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах,

Ес . Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

Эмнэлгийн даргын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.

**Улсын хоёрдугаар төв эмнэлгээс холбогдох байгууллагуудыг
мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зураглал**



ЭРШЛТ МЭНДИЙН САЙРЫН
2013 ОНЫ 11 дугаар сарын 06-ны өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ДАРГА

Удирдлагын зөвлөл
Эрдмийн зөвлөл
Дүрэмд заасан бусад хороо, зөвлөл

Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Стратеги, төлөвлөлт эрхэлсэн орлогч дарга

Чнарын алба
Санхүү бүртгэлийн алба
Хүний нөхцийн алба
Сургалт, судалгаа, гадаад харилцааны алба
Үндэсний онцшлэгийг эмчилгээнд төслийн бат

Параクリニック
Нэгдсэн лабораторийн тасаг
Дурс оношилгооны тасаг
Сэргээн засах эмчилгээний тасаг
Эм зүйн тасаг
Ариутгал, холдварчийгүйгэйн тасаг
Эмчилгээний хоол зүйн тасаг

Стационар
Гематологи
Нэн судалан
Эмтэг судалан
Чанд авив очишлэгээ
Радиологийн хасаг
Комьюнит томограф
Дургантин хасаг
Мэдрэп судаллын тасаг
Бөөр, дотод шүүрлийн буличиж судаллын тасаг
Мэдрэп судаллын тасаг
Мэс засал судаллын тасаг
Бөөр, шаэсний замын №3-ын тасаг
Мэдээлгүүжүүлэл, эрчимт эмчилгээ, ярилтай тусламжийн тасаг

Амбулатор
Төгрөгийн орфны эмчилгээний кабинет
Гастроентеролог, цус судаллын тасаг
Зүрх судас, үе мөч судаллын тасаг
Ушиг судаллын тасаг
Берер, дотод шүүрлийн буличиж судаллын тасаг
Мэдрэп судаллын тасаг
Мэс засал судаллын тасаг
Бөөр, шаэсний замын №3-ын тасаг
Ярилтай тусламжийн хасаг
Дургантин мас засалын хасаг
БИЭМЗ-ийн тавьжинет
Ярилтай тусламжийн хасаг
Дургантин хасаг
Өвдэлт намндаах хасаг
Хүүхийн тасаг
Хүүхийн кабинет
Арьсны кабинет
Нийгмийн кабинет

Төлөвлөлт, маркетинг, эдийн засийн алба
Статистик мэдээлэл
Эрүүл мэндийн давтгал
Мэдээллийн технологи
Цахим бүртгэл
Сувилхайх алба
Инженер техник, хангамж, үйлчилгээний алба
Барилга, сантехникийн засвар үйлчилгээний тасаг
Угаалга, үйлчилгээний тасаг
Эмнэлгийн тоног төрөөрөмжийн тасаг
Автогаражийн тасаг
Харуул хамгаалалт
Арьсны кабинет
Нийгмийн кабинет
Чих хамэр хөөлжийн кабинет
Эмзэгтэйчүүдийн кабинет
Хоол зүйл
Чиг судалач
Нийтийн ажлынтан